



**ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗРЫН ХАРЬЯА
ХЭНТИЙ АЙМГИЙН АУДИТЫН ГАЗАР**

*Үндэсний аудитын газрын үйл ажиллагааны
2015 оны төлөвлөгөөний дагуу хийсэн
ГҮЙЦЭТГЭЛИЙН АУДИТ*

**ХИЛ ОРЧМЫН БАЙГАЛЬ ОРЧНЫГ ХАМГААЛАХ ТАЛААРХ ТӨРИЙН
ЗОХИЦУУЛАЛТЫН ҮР НӨЛӨӨТ БАЙДАЛ**



**ХИЛ ДАМНАСАН ТҮЙМРЭЭС ХАМГААЛАХ ШОРООН ЗУРВАС
БАЙГУУЛСАН БОЛОВЧ, ДАХИН СЭРГЭЭЛТ ХИЙГДЭХГҮЙГЭЭС УЛСЫН
БОЛОН ОРОН НУТГИЙН ТӨСВИЙН ХӨРӨНГӨ ҮР АШИГГҮЙ
БОЛОХОД ХҮРЧ БОЛЗОШГҮЙ БАЙНА.**

2015 он Чингис хот

АГУУЛГА

Тайлан бэлтгэсэн Хэнтий аймгийн Аудитын газар Тэргүүлэх аудитор Ц.Энхтүвшин Ахлах аудитор Н.Туяа Шинжээч Б.Мөнгөнцэцэг 2015 оны 10 дугаар сар Аудитын тайлан дүгнэлттэй холбоотой асуудлаар нэмж тодруулах, асууж лавлах зүйл байвал аймгийн Аудитын газрын 7056-2147 тоот утсаар харилцана уу. Хаяг Хэнтий аймгийн Аудитын газар. Аймгийн ЗДТГ-ын байр. 325 тоот өрөө	Агуулга	1
	Товчилсон үгийн тайлбар	2
	Аудитын зорилт, хамарсан хүрээ, арга зүй	3
	Аудитад ашигласан хууль тогтоомж, шалгуур үзүүлэлт	4
	Аудитын багийн бүрэлдэхүүн	4
	Ерөнхий мэдээлэл	5
	Нэгдүгээр бүлэг: Хил орчмын байгаль орчныг хамгаалах талаар Засгийн газар хооронд байгуулсан гэрээ, хэлэлцээрүүд, үр дүн	6-9
	1.1 Хил орчмын ой, хээрийг хамгаалах талаар Монгол Улс, ОХУ-ын Засгийн газрын хооронд гэрээ хэлцэл байгуулагдсан ч Талууд түүнийг хэрэгжүүлэх ажил тодорхой үр дүнд хүрэхгүй байна.	
	1.2 Хилийн усыг хамгаалах, ашиглах тухай хэлэлцээрийн заалтууд хэрэгжээгүй байна	
	1.3 Хил орчмын ховор ургамал, амьтныг хамгаалах, хамтран судлах гэрээ хэлэлцээрийн дагуу ОХУ-ын Сохондын ШМДГ, ОББЦГ-ын хамгаалалтын захиргаатай хамтран нэн ховор, ховор шувуудын судалгаа хийсэн байна.	
	Хоёрдугаар бүлэг: Төрийн захиргааны төв, орон нутгийн байгууллагуудын хил орчмын байгаль орчныг хамгаалах талаарх үйл ажиллагаа	10-20
	2.1 Хил дамнан гарч байгаа ой хээрийн түймрээс сэргийлэх, хамгаалах зорилгоор шороон зурвас байгуулсан боловч шороон зурвасыг дахин сэргээлт хийгдэхгүй байгаагаас төсвийн хөрөнгө үр ашиггүй болоход хүрч болзошгүй байна	
	2.2 Хил орчмын усны чанар байдлын талаарх мэдээллийг иргэд байгууллагаас өгч байсан боловч усны мэргэжлийн байгууллага болох ОГСГЗ тодорхой арга хэмжээ аваагүй байна	
	2.3 Хан Хэнтийн тусгай хамгаалалттай газрын хамгаалалтын захиргаа, ОББЦГ-ын хамгаалалтын захиргаа нь хил хамгаалах байгууллага, орон нутгийн засаг захиргааны байгууллагатай хамтарч ажиллаж байгаа гэх боловч аймгийн БОАЖГ-т хамтран ажиллаж байгаа талаарх мэдээлэл байхгүй байна.	
	Гуравдугаар бүлэг: Хил орчмын байгаль орчныг хамгаалахад зориулсан улс, орон нутгийн төсвийн хөрөнгийн үр нөлөө	21-23
	3.1 Улс орон нутгийн төсвөөс хил орчмын байгаль хамгаалахад тусгайлан хөрөнгө төлөвлөөгүй, шороон зурвас байгуулах хөрөнгө хангалттай хүрэлцэхгүй байна	
	3.2 Хил орчмын байгаль орчныг хамгаалахад зарцуулсан төсвийн хөрөнгө бүрэн зарцуулагдсан байна.	
	3.3 Түймрээс учирсан хохирлын экологи, эдийн засгийн үнэлгээг сумын Засаг даргын захирамжаар томилогдсон комисс тогтоожээ.	
	ДҮГНЭЛТ	23
	ЗӨВЛӨМЖ	24

ТОВЧИЛСОН ҮГИЙН ТАЙЛБАР

ҮГИЙН ТОВЧЛОЛ	ТОВЧИЛСОН ҮГИЙН ТАЙЛАЛ
ОХУ	Оросын Холбооны Улс
ҮАГ	Үндэсний аудитын газар
БОАЖГ	Байгал орчин аялал жуулчлалын газар
БОНХЯ	Байгаль орчин ногоон хөгжлийн яам
ОБЯ	Онцгой байдлын яам
ХХЕГ	Хил хамгаалах ерөнхий газар
ОБЕГ	Онцгой байдлын Ерөнхий газар
ОБХ	Онцгой байдлын хэлтэс
ОБГ	Онцгой байдлын газар
УЦУОША	Ус цаг уур орчны шинжилгээний алба
ОББЦГ	Онон Балжийн байгалийн цогцолборт газар
ДЦГ	Дархан цаазат газар
ТХГ	Тусгай хамгаалалттай газар
ЗДТГ	Засаг даргын тамгын газар
ДБХС	Дэлхийн байгаль хамгаалах сан
ГТТХ	Гал түймэртэй тэмцэх хэлтэс
ИТХ	Иргэдийн Төлөөлөгчдийн Хурал
ОУБ	Олон улсын байгууллага
ШУА	Шинжлэх ухааны академи
ХХК	Хязгаарлагдмал хариуцлагатай компани
БОШ	Байгаль орчны шинжилгээ
ШМДГ	Шим мандлын дархан газар
БОХУБ	Байгаль орчны хяналтын улсын байгууллага
ААНБ	Аж ахуйн нэгж байгууллага
БЭТ	Бүрэн эрхт төлөөлөгч
НҮБ	Нэгдсэн Үндэстний байгууллага
ОНХС	Орон нутгийн хөгжлийн сан

Аудитын зорилт, хамарсан хүрээ, арга зүй, стандартын талаарх мэдэгдэл

1. Аудит хийх үндэслэл, бүрэн эрх:

Аудитыг ОХУ-ын Тооцооны танхим болон Монгол Улсын Үндэсний аудитын газрын хооронд 2012 онд байгуулсан хэлэлцээр, Монгол Улсын Ерөнхий аудиторт ҮАГ-аас 2015 онд нийлүүлэх бүтээгдэхүүн, ажил, үйлчилгээний төлөвлөгөөг үндэслэн Төрийн аудитын тухай хуулиар тодорхойлсон аймгийн Аудитын газрын бүрэн эрхийн хүрээнд хийв.

Аудитын зорилт:

ОХУ-тай хиллэх Хэнтий аймгийн хилийн дагуух ой, усан сан, ховор ургамал амьтны аймаг, тусгай хамгаалалттай газар нутгийн үйл ажиллагаа, байгаль орчныг хамгаалах төрийн зохицуулалтын үр нөлөөт байдлыг шалган дүгнэлт, санал, зөвлөмж боловсруулан дүнг ҮАГ танилцуулахад аудитын зорилго чиглэгдсэн.

Дээрх зорилтыг хангахын тулд дараах чиглэлээр аудит хийв. Үүнд:

- Хил орчмын байгаль орчныг хамгаалах талаар Засгийн газар хоорондын гэрээ хэлэлцээрүүд үр дүнтэй хэрэгжсэн эсэх ,
- Төрийн захиргааны төв, орон нутгийн байгууллагууд хил орчмын байгаль орчныг хамгаалах талаар үр нөлөөтэй ажиллаж буй эсэх,
- Хил орчмын байгаль орчныг хамгаалахад зориулсан улс, орон нутгийн төсвийн хөрөнгө үр нөлөөтэй зарцуулагдсан эсэх,

1. Аудитад хамрагдсан хүрээ:

Аудитад Хилийн 0287 дугаар анги, аймгийн БОАЖГ, ОБГ, УЦУОША, ОББЦГХЗ, Хан Хэнтийн ДЦГ-ын Онон хэсэг, Онон голын сав газрын захиргаа, Дадал, Батширээт, Биндэр, Өмнөдэлгэр сумдын байгаль хамгаалагчдын гаргасан 2012-2015 оны тайлан, судалгаа зэрэг хилийн дагуух сум, орон нутгийн засаг захиргааны болон холбогдох байгууллагуудыг хамрууллаа.

Аудитад 2012-2015 оны үйл ажиллагааг хамруулсан болно.

2. Аудитын арга зүй:

Аудитыг гүйцэтгэхэд ОХУ-ын Тооцооны танхим болон Монгол Улсын ҮАГ хоорондын хэлэлцээр, Төрийн хяналт шалгалтын стандарт, гүйцэтгэлийн аудитын гарын авлага, Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан төлөвлөгөө, хөтөлбөрийн дагуу дараах арга зүйг ашиглав. Үүнд:

- Аудитад хамрагдсан байгууллагуудын албан тушаалтнуудтай ярилцлага хийх, тайлбар тодруулга авах, судалгаа гаргуулах
- Хилийн дагуух байгаль орчны төлөв байдалд хээрийн ажиглалт хийх, зураг авч баталгаажуулах
- Гол мөрний уснаас дээж авах, шинжлэх, нэгтгэн дүн шинжилгээний үр дүнг үндэслэж дүгнэлт хийх

Төрийн хяналт шалгалтын стандарт, гүйцэтгэлийн шалгалтын журмын дагуу аудитын дүн, дүгнэлтэд дэмжлэг болох нотлох зүйл цуглуулж, холбогдох мэдээ судалгаа, тайлан, тайлбарыг аудитын ажлын баримтад хавсаргав.

3. Аудитад ашигласан шалгуур үзүүлэлтүүд

- Байгаль орчныг хамгаалах тухай хууль
- Ойн тухай хууль
- Усны тухай хууль
- Ургамал хамгааллын тухай хууль түүнтэй нийцүүлэн гаргасан бусад хууль тогтоомж, эрх зүйн актууд
- “Ойг түймрээс хамгаалах тухай” Монгол Улсын Засгийн газар, ОХУ-ын Засгийн газар хоорондын хэлэлцээр /2014.09.03/
- “Хилийн усыг хамгаалах, ашиглах тухай” Монгол Улс, ОХУ-ын Засгийн газар хооронд байгуулсан хэлэлцээр /1995.02.11/
- ОХУ-ын Тооцооны танхим, Үндэсний аудитын газрын хооронд хамтран ажиллах тухай хэлэлцээр, санамж бичгүүд
- Монгол Улсын Засгийн газрын 2013 оны 06 дугаар тогтоол

4. Аудитын хугацаа.

Аудитыг 2015 оны 09 дүгээр сарын 14-нөөс эхлэж, 2015 оны 10 дугаар сарын 30-нд дуусгав.

5. Аудит хийсэн багийн бүрэлдэхүүн:

Аудитыг Хэнтий аймгийн Аудитын газрын дарга, тэргүүлэх аудитор Ц.Энхтүвшин хянан удирдаж, ахлах аудитор Н.Туяа, шинжээч Б.Мөнгөнцэцэг нар хийж гүйцэтгэлээ.

Аудитад ҮАГ-ын Чанарын баталгаажуулалтын албаны дарга, менежер Г.Цэдэнбалжир, Хилийн 0287 дугаар ангийн захирагч, хурандаа Ж.Жамсрандорж, БОАЖГ-ын дарга Г.Энхбаяр, ОБГ-ын гамшгаас хамгаалах улсын хяналтын байцаагч П.Батхуяг, УЦУОША-ны Хэрлэн-Өндөрхаан усны харуулын техникч Л.Даваадорж нар оролцов.

ЕРӨНХИЙ МЭДЭЭЛЭЛ

Хэнтий аймаг нь ой, хээр тал хосолсон 83,0 мянган км² газар нутагтай бөгөөд хойд талаараа ОХУ-ын Өвөрбайгалийн хязгаарын Чита мужтай 232,5 км газар, зүүн талаараа Дорнод, зүүн урд талаараа Сүхбаатар, баруун урд талаараа Дорноговь, Говьсүмбэр, баруун талаараа Төв, Сэлэнгэ аймгуудтай хиллэдэг. Газарзүйн байршлын хувьд хойд талаас Сибирийн ой тайга уулсыг даган өмнө зүг түрж, өмнө талаараа Төв Азийн хээр, уулын хээр, хээрийн бүс голлоно.

Нутгийн хойд талаараа Хэнтийн нурууны салбар уулс орчимд 188.8 мянган га талбайд ойн сан бүхий газартай. Ойн сангийн 31,1 %-ийг Өмнөдэлгэр, 33,5 %-ийг Батширээт, 10,5 %-ийг Биндэр, 12,2%-ийг Дадал, 8.7%-ийг Хан Хэнтийн ДЦГ, 4%-ийг ОББЦГ тус тус эзэлж байна.

Тус аймагт Хан Хэнтийн дархан цаазат газар, Онон Балж, Өндөрхаан уулын байгалийн цогцолборт газар, Тосон Хулстай, Дархан Уул, Хэрлэн тооно уул, Хар Ямаатын байгалийн нөөц газар, Биндэрьяа хан уул, Хангал нуурын дурсгалт газруудтай.

Нутгийн хойд хэсэг хангай хөвчдөө хандгай, баавгай, хүдэр, илбэнх, гахай, шилүүс, булга зэрэг амьтадтай, нутгийн урд хэсгээр цагаан зээр, аргаль нутагладаг. Хэрлэн, Онон, Балж, Улз голууд загас, усны амьтан, ургамлын зүйлийн бүрэлдэхүүний нөөцөөр арвин бөгөөд Хэрлэн голын савд 24, Онон голын саваар 38 зүйл загастай, нутгийн төв болон хойд хэсгээр нүүдлийн шувууд олноор ирж нутагладаг.

Аймгийн нутаг дэвсгэрийн гадаргын ус нь Төв Азийн цэвэр усны эх үүсвэр болж байдаг бөгөөд Номхон далайн ай савд Онон, Хэрлэн, Улз голууд, Хойд мөсөн далайн ай савд Минж гол хамрагддаг.

Чингисийн гурван нуур, Хар зүрхний хөх нуур, Гүрмийн, Аварга, Тосон зэрэг нууруудтай. Онон, Хэрлэн голуудын савд жижиг нуурууд олон, Улаалзгана, Онон, Тарс, Арангат зэрэг рашаанууд бий.

**НЭГДҮГЭЭР
БҮЛЭГ**

**•ХИЛ ОРЧМЫН БАЙГАЛЬ ОРЧНЫГ ХАМГААЛАХ ТАЛААР
ЗАСГИЙН ГАЗАР ХООРОНД БАЙГУУЛСАН ГЭРЭЭ,
ХЭЛЭЛЦЭЭРҮҮД, ҮР ДҮН**

1.1 Хил орчмын ой, хээрийг хамгаалах талаар Монгол Улс, ОХУ-ын Засгийн газрын хооронд гэрээ хэлцэл байгуулагдсан ч Талууд түүнийг хэрэгжүүлэх ажил тодорхой үр дүнд хүрэхгүй байна.

1.8 Монгол Улсын Засгийн газар, ОХУ-ын Засгийн газар хоорондын “Ойг түймрээс хамгаалах тухай” 2014 оны 9 дүгээр сарын 3-ны өдрийн хэлэлцээрээр

- Хил орчмын нутаг дэвсгэрт ойн болон хээрийн түймрээс урьдчилан сэргийлэх, түүнийг унтраах, түүнээс учирсан хохирлыг багасгах ажлыг сайжруулах;
- Ойн болон хээрийн түймэртэй тэмцэх чиглэлээр харилцан туслалцаа үзүүлэх болон туршлага солилцох;
- Ойн болон хээрийн түймрээс урьдчилан сэргийлэх болон түүнийг унтраах хоёр талын үр ашигтай харилцан ажиллагааг хөгжүүлэх хүсэл эрмэлзлээ илэрхийлэн дараах зүйлийг тохиролцсон байна.

эдгээр заалтууд орон нутагт хэрэгжээгүй байна.

1.9 Тухайлбал: Хэлэлцээрийн 1 дүгээр зүйлд “Талууд ойн болон хээрийн газар нутгийг түймрээс хамтран хамгаалах бүсийг тогтоох бөгөөд энэ бүсэд Монгол Улсын болон ОХУ-ын хилийн шугамаас Тал тус бүрийн нутаг дэвсгэр дээрх 10 км өргөн зурвас хамаарна” гэж заасан.

Энэ заалтыг хоёр Тал бүрэн хэрэгжүүлээгүй байна.

1.10 Хэлэлцээрийн 5 дугаар зүйлийн 2-т “Нэг Талын улсын нутаг дэвсгэрээс нөгөө Талын улсын нутаг дэвсгэр рүү ойн болон хээрийн түймэр тархан орсон тохиолдолд тухайн нөгөө Талын эрх бүхий байгууллага уг түймэр үүссэн нутаг дэвсгэрийн Талын эрх бүхий байгууллагад хандан тусламж хүсэх, түүний дотор гал унтраах хүч болон хэрэгсэл авахаар хандаж болох бөгөөд түймэр гарсан шалтгаан, түүний үр дагаврыг илрүүлэхэд чиглэсэн хамтарсан судалгаа явуулж болно”

Энэ заалтыг хэрэгжүүлж 2015 онд ОХУ-аас хил даван орж ирсэн эхний удаагийн түймрийг унтраах ажиллагаанд ОХУ-аас 10 хүн, 2 нэгж техник хэрэгсэл оролцсон болно.

1.11 Хил дамнасан ой, хээрийн түймрээс урьдчилан сэргийлэх, үр дагаврыг арилгах асуудлыг шийдвэрлэх зорилгоор Дорнод, Хэнтий аймгуудын ОБХ, ОХУ-ын ОБЯ-ны Байгалийн хязгаар дахь ерөнхий газар хоорондын хамтын ажиллагааг зохицуулах хэлэлцээрийг 2010 оны 4 дүгээр сарын 13-ны өдөр Өндөрхаан хотод хийсэн байна.

1.14 Энэ хэлэлцээрийг 2014 оны 12 дугаар сарын 31-ний өдөр хүртэлх хугацаатайгаар байгуулсан бөгөөд хэлэлцээрийн 5.5 дах заалтад “хүчинтэй хугацаа

дуусахаас 6 сарын өмнө талуудын аль нь ч түүний үйлчлэлийг дуусгавар болох хүсэлтээ бичгээр гаргаагүй тохиолдолд хэлэлцээрийн хугацааг дахин нэг жилээр сунгасанд тооцно” гэж заасан энэ он дуустал хүчинтэй хэвээр байна.

Уг хэлэлцээрийн 2.1-д “...Талууд байгалийн түймрийг улсын хил давуулахгүй байх урьдчилсан нөхцлийг бий болгох талаар дараах урьдчилан сэргийлэх арга хэмжээг авч хэрэгжүүлэхээр заажээ. Тухайлбал:

- *Байгалийн түймрийг унтраах эрх бүхий болон түймэр унтраах үйл ажиллагаанд оролцдог байгууллага ... тэдгээрийг түймэр унтраах арга зүйд сургах сургалтад оролцоно;*
- *“Хуурай өвсийг төлөвлөгөөтэйгээр шатаах, түймрээс хамгаалах зурвас татах.*
- *Талууд хил дамнасан түймрийн аюулын талаар харилцан мэдээлэх журмыг тогтмол тодотгоно.*

Эдгээр заалтын дагуу хоёр улсын гал сөнөөгч нарын нэгдсэн сургалтыг зохион байгуулж, түймрийн талаарх харилцан мэдээлэл солилцож ажилласан байна.

Тухайлбал, ОХУ-ын Өвөр байгалийн хязгаарын Онцгой байдлын алба, Хэнтий, Дорнод, Сүхбаатар аймгийн Онцгой байдлын газар, хэлтсийн удирдлага ой, хээрийн түймрээс урьдчилан сэргийлэх тэмцэх талаар уулзалтыг жил бүр зохион байгуулж, ОХУ-ын Өвөр байгалийн хязгаарын Кыра районы Онцгой байдлын алба, Хэнтий, Дорнод аймгийн Онцгой байдлын газар, хэлтсийн Эрэн хайх аврах салбаруудын хамтарсан сургуульд нийт 15 хүнийг Кыра районы Чита мужийн Онцгой байдлын албанд сургалтанд хамруулсан байна.

Хэнтий аймгийн ОБГ, ОХУ-тай хамтарсан уулзалт, сургалт



Түймрийн мэдээллийг талууд хил дамнасан гарсан үед харилцан мэдээлж байгаа боловч тодорхой арга хэмжээ авч ажиллаж чадахгүй байна. Иймээс гэрээний дээрх заалтууд бүрэн хэрэгжихгүй байгаа юм.

Хэлэлцээрийн 4.1-т “Хил дамнасан байгалийн түймрийг унтраах болон хил залгаа Талын ойн түймрийн анги хэсгийг татан оролцуулсантай холбогдон гарах зардлыг

Засгийн газар хоорондын холбогдох хэлэлцээрийн үндсэн дээр нөхөн төлнө” гэсэн заалт хоёр улсын хувьд хэрэгжээгүй.

2010 оны 4 дүгээр сарын гэрээ хэлцлийг үндэслэн Монгол Улсын ОБЕГ, Дорнод, Хэнтий, Сүхбаатар аймгуудын Онцгой байдлын газар, хэлтсүүд, ОХУ-ын Өвөрбайгалийн хязгаарын Онцгой байдлыг удирдах газрын дарга нарын хамтын ажиллагааны уулзалт 2013 оны 3 дугаар сарын 21-ний өдөр Дорнод аймагт, 2014 оны 11 дүгээр сарын 17-ны өдрөөс 4 хоногийн хугацаанд ОХУ-ын Чита мужийн Өвөрбайгалийн Хязгаарын Чита хотод тус тус зохион байгуулагдсан байна.

Уулзалтаар Талууд хоёр улсын хил орчмын бүс нутагт сүүлийн жилүүдэд тохиолдсон ой хээрийн түймрийн нөхцөл байдлын талаарх мэдээлэл танилцуулгыг хийж, ой хээрийн түймэртэй тэмцэх үйл ажиллагаанд тулгамдаж байгаа хүндрэл бэрхшээлүүдийг хэлэлцэж, цаашид хэрэгжүүлэх хамтын ажиллагааны талаар санал солилцжээ.

1.2 Хилийн усыг хамгаалах, ашиглах тухай хэлэлцээрийн заалтууд хэрэгжээгүй байна.

1.15 “Хилийн усыг хамгаалах, ашиглах тухай” Монгол Улс, ОХУ-ын Засгийн газрын 1995 оны 2 дугаар сарын 11-ний өдрийн хэлэлцээрийн хоёрдугаар зүйлд хилийн усыг хамгаалах, ашиглах талаар талуудын хамтын ажиллагааг дараах чиглэлээр явуулахаар заасан. Үүнд:

- *Усны нөөцийг экологийн үндэслэлтэйгээр жолоодох үүднээс хилийн усны нөөцийг зохистой ашиглах, түүнийг бохирдох, хомсдохоос хамгаалах;*
- *Ус, усны хими, усны биологи, голдрилын горим болон усны нөөц, чанарыг судлах;*
- *Үерээс урьдчилан сэргийлэх, сөрөг үр дагавраас зайлсхийх зорилгоор ус судлалын мэдээлэл, урьдчилсан мэдээ солилцох;*
- *Хилийн усыг бохирдлоос хамгаалах, чанарт нь хяналт тавих зэрэг чиглэлээр ажиллах ёстой*

1.16 Талууд энэ хэлэлцээрийн хоёрдугаар зүйлийг хэрэгжүүлэх зорилгоор

- *Хилийн усны ажиглалт, шинжилгээний нэгдсэн аргачлал, тохиролцсон цэгүүдийн жагсаалт, усны сорьц авах үечлэл зэргийг тусгасан мониторингийн хөтөлбөр боловсруулах, хэрэгжүүлэх;*
- *Харилцан тохиролцсон журмын дагуу ус судлал, усны хими усны биологийн мэдээлэл солилцох;*
- *Усны нөөцийг хамгаалах, зохистой ашиглах асуудлаар хамтарсан шинжилгээ, судалгаа явуулах*
- *Усны чанарын үзүүлэлтүүдийг олон улсын нормативт нийцүүлэн тохиролцох*
- *Усны нөөцийг хамгаалах, зохистой ашиглах, салбарт хамтарсан шинжилгээ, судалгаа явуулах, туршлага судлах зорилгоор мэргэжилтэн солилцох гэж хэлэлцээрт заасан байдаг.*

Монгол Улс, ОХУ-ын Засгийн газрын хооронд “Хилийн усыг хамгаалах, ашиглах тухай” хэлэлцээрийн дээрх заалтууд 2012-2015 онд орон нутагт хэрэгжээгүй байна.

1.3 Хил орчмын ховор ургамал, амьтныг хамгаалах, хамтран судлах гэрээ хэлэлцээрийн дагуу ОХУ-ын Сохондын ШМДГ, ОББЦГ-ын хамгаалалтын захиргаатай хамтран нэн ховор, ховор шувуудын судалгаа хийсэн байна.

1.3.1 Аймгийн БОАЖГ: Эко-Ази дээд сургуулийн судалгааны багтай “Нэн ховор, ховор болон ашиглалтанд өртөмтгий ургамлын тархац нөөцийн судалгаа”-ны ажлын гэрээ байгуулж, Аймгийн Засаг даргаар батлуулан БОНХЯ-ны 8,0 сая төгрөгийн санхүүжилтээр Хэнтий аймгийн Батширээт, Биндэр, Дадал зэрэг сумдын хил дагуух нутгуудад хил орчмын ховор ургамлын тандалт судалгааг хийж гүйцэтгэсэн байна.

Судалгаагаар 15 зүйлийн нэн ховор, 23 зүйлийн ховор ургамал бүртгэгдэж, эдгээр ургамлуудын 35 хувь нь Монгол улсын “Улаан ном”-д бүртгэгдэн дархлагдсан ургамлууд болохыг тогтоожээ.

Байгаль цаг уурын өөрчлөлт, хуурайшилтын улмаас нэн ховор, ховор ургамлын тархац хумигдаж өмнөх судалгаанд бүртгэгдсэн ургамлууд бараг тааралдахгүй, Монгол хундгана, Тагийн сөд зэрэг нэн ховор ургамал тааралдаагүй, Батширээт сумын Цээнэтийн цагаан, Ягаан цээнийн тархалтын хүрээ хумигдсаныг судалгаагаар тогтоожээ.

1.3.2 “Си Ти Би ХХК”-тай “Хэнтий аймагт нарийвчилсан агнуур зохион байгуулалт явуулах, агнуурын бүс нутгуудын менежментийн төлөвлөгөөг боловсруулах” ажлын гэрээг 2013 онд байгуулж, аймгийн ЗДТГ-ын даргаар батлуулан ажлын гүйцэтгэлийг 2014 оны 05 дугаар сарын 15-ны өдөр комиссын актаар хүлээн авсан байна.

1.3.3 Онон Балжийн БЦГ-ын хамгаалалтын захиргаа: ОХУ-ын Сохондын ШМДГ-ын захиргаатай 2009 оноос хойш хамтран ажиллах төлөвлөгөөг жил бүр гарган баталж, улсын хил дамнан нүүдэллэдэг зүйлүүд, ойн тууртны цөм байршил нутаг, нүүдлийн зүйлүүдийн шилжилт хөдөлгөөн, тоо толгойг тогтоох зэрэг судалгааны ажлыг жил бүр хийж иржээ.

Мөн нэн ховор, ховор шувуудын мониторинг судалгааг ОББЦГ-ын хязгаарлалтын бүсийн Монгол Улсын хилийн дагуу газруудад жилд 2-3 удаа хийж гүйцэтгэн ажиглалт мэдээллийг биологийн олон янз байдлын ажиглалтын биосан програмд төвлөрүүлэн тайланг гаргажээ.

1.3.4 Хилийн 0287 дугаар ангийн албан хаагчдаас идэвхтэн байгаль хамгаалагчид хил дагуух зэрлэг амьтдын шилжилт хөдөлгөөн, байршил, тандалт мониторинг судалгааг арга зүйн дагуу хийж 7 зүйлийн 215 бодгалийг Онон Балжийн БЦГ-ын биологийн олон янзын байдлын ажиглалтын биосан програмд бүртгүүлжээ.

**ХОЁРДУГААР
БҮЛЭГ**

**• ТӨРИЙН ЗАХИРГААНЫ ТӨВ, ОРОН НУТГИЙН
БАЙГУУЛЛАГУУДЫН ХИЛ ОРЧМЫН БАЙГАЛЬ
ОРЧНЫГ ХАМГААЛАХ ТАЛААРХ ҮЙЛ АЖИЛЛАГАА**

2.1 Хил дамнан гарч байгаа ой хээрийн түймрээс сэргийлэх, хамгаалах зорилгоор шороон зурвас байгуулсан боловч шороон зурвасыг дахин сэргээлт хийгдэхгүй байгаагаас төсвийн хөрөнгө үр ашиггүй болоход хүрч болзошгүй байна.

2.1.1 БОНХ-ын сайдын 2012 оны 01 тоот ой хээрийг түймрээс урьдчилан сэргийлэх, хамгаалах зарим арга хэмжээний тухай албан даалгаврыг аймаг сумын Засаг дарга нарт хүргүүлжээ.

Албан даалгаврын дагуу аймгийн Засаг дарга ой хээрийг түймрээс урьдчилан сэргийлэх, тэмцэх зарим арга хэмжээний тухай албан даалгаврыг 2012-2015 онд жил бүр гаргаж, сумдын Засаг дарга нар болон холбогдох байгууллага албан тушаалтанд үүрэг өгч ажиллажээ.

Аймгийн БОАЖГ сайдын албан даалгаврын хүрээнд хавар намрын хуурайшилтын үед шуурхай жижүүр ажиллуулан цаг үеийн мэдээллийг БОНХЯ-д хүргэж, түймрийн эрсдэлтэй Дадал, Биндэр, Батширээт, Баян-Адрага, Өмнөдэлгэр Цэнхэрмандал сумдын ойд аялал зугаалга, мод бэлтгэл, ойн дагалт нөөц ашиглах үйл ажиллагааг хориглон зогсоосон байна.

Орон нутгийн засаг захиргаа болон байгаль хамгаалагч, нөхөрлөлүүдтэй хамтран 2012 онд аймгийн хэмжээнд 265 удаагийн эргүүл хяналтыг ажиллуулж энэ үйл ажиллагаанд 286 ААН байгууллага 1290 тээврийн хэрэгсэл, 3709 иргэн хамрагдаж, 136 зөрчил дутагдлыг арилгуулсан байна. Ажиллагааны үеэр 4560 ширхэг санамж анхааруулга тарааж, 6287 айл өрх 1264 иргэнд хүрч үйлчилсэн байна.

Ой хээрийн түймрээс урьдчилан сэргийлэх зорилгоор ой бүхий сумдын ААНБ, ойн мэргэжлийн байгууллага, ойн нөхөрлөлүүд болон иргэдэд 158 удаагийн сургалт сурталчилгааг зохион байгуулсан байна.

2.1.2 БОНХ-ийн сайд 2013 онд “Ой хээрийн түймрээс урьдчилан сэргийлэх, хамгаалах ажлыг зохицуулах зөвлөл” байгуулж ажиллах тухай аймгийн Засаг дарга нарт 2013 оны 1/347 тоот албан бичиг хүргүүлжээ. Үүний дагуу аймгийн ИТХ-ын Тэргүүлэгчдийн 2013 оны 62 дугаар тогтоолоор аймгийн Засаг даргын орлогчоор ахлуулсан ой хээрийн түймрээс урьдчилан сэргийлэх, хамгаалах зөвлөлийг 17 хүний бүрэлдэхүүнтэйгээр байгуулж, зөвлөлийн дүрмийг баталжээ. Гэвч Зөвлөлийн үйл ажиллагаатай холбоотой ажлын талаар тодорхой төлөвлөгөө, тайлан мэдээ байхгүй байна.

2.1.3 Аймгийн ОБГ 2012-2015 оны хооронд жил бүр 20-30,0 сая төгрөгийг ой, хээрийн түймрээс урьдчилан сэргийлэх, унтраах ажлын талаар сургалтад төсөвлөн зарцуулж, ой хээрийн түймэр гарах эрсдэл ихтэй сумдын ЗДТГ, ААНБ, БОХУБ, Багийн Засаг дарга нарыг оролцуулан дадлага сургуулилт хийж бэлэн байдлын үзлэгийг бүх сумдад зохион байгуулж, цаг үеийн байдал үүсгэн ажиллуулж штабын дадлага хийж иржээ.

2.1.4 Аймгий ОБГ-т Дэлхийн байгаль хамгаалах сангийн дэргэдэх “Нутгийн иргэдэд түшиглэсэн байгалийн менежментээр ядуурлыг бууруулах” төслийн 5,7 сая

төгрөгийн үнэ бүхий түймэр унтраах багаж зэвсэглэмж, цуравдагч-2 ш, 6 ме-/28-32/ маркын түймрийн багаж 5 ш, 6 ме-/32/ маркын түймрийн багаж 4 ш, РЛО-5 ш, галд тэсвэртэй бүтээлэг-8ш хувиарлан олгож хүлээлгэн өгчээ.

Аймаг, сумын Засаг даргын албан даалгаврын дагуу түймрийн нөхцөл байдлыг ажиглах, байнгын эргүүл хамгаалалт, хяналт шинжилгээ хийх эргүүл хамгаалалтын ажилтныг тусгайлан ажиллуулж, тодорхой хэмжээний урамшуулал олгодог ба энэ ажил хийгдэж хэвшсэн байна.

2.1.5 Өдөр бүрийн зөвхөн 11 цагт сансрын зураг авч мэдээ өгдөг ба бусад цагт гарсан түймрийн зургийг авах боломжгүй байдаг байна.

2.1.6 Мөр хянах шороон зурвас байгуулах, дахин сэргээх, шатаах аргаар харлуулсан зурвас байгуулах ажлыг 2012-2015 онд зохион байгуулсан нь Монгол улсаас ОХУ-руу хил дамнан ой хээрийн түймэр гараагүй үр дүнтэй ажил болжээ.

2.1.7 Аймгийн ОБГ-аас ОХУ-ын Өвөрбайгалийн хязгаарын ОБУГ-т хил дамнасан түймрийн мэдээллийг шууд бус ОБЕГ-ын Гал түймэртэй тэмцэх газарт дамжуулж өгдөг байна. ОБГ-аас шифрийн мэдээ /түймрийн талаарх мэдээ/-г тодорхой заалтаар гаргаж, сар бүрийн 20-нд тогтмол мэдээлдэг ба түймрийн үед 30 минутын дотор өгдөг байна.

2.1.8 ОХУ-ын хил дагуу түймэртэй байгаа тохиолдолд ОБЕГ, Хилийн цэргийн ангиудад шууд холбогдож мэдээллээ хүргэдэг ба ОХУ-ын ОБУГ-тай шууд холбогдох боломжгүй байдаг байна.

Хилийн дагуух ойн санг хамгаалах талаар

2.1.9 Сумдад бэлтгэх модны дээд хязгаарыг аймгийн ИТХ-аар жил бүр хэлэлцүүлэн баталдаг ба үндсэн ашиглалтын огтлолтыг 3 компани, арчилгаа, цэвэрлэгээний огтлолтыг 7 компани хийж, хэрэглээний болон түлшний мод бэлтгэж байгаа бөгөөд ойн нөхөрлөлүүд менежментийн төлөвлөгөөний дагуу өөрийн эзэмшлийн ойн санд цэвэрлэгээ хийж түлшний мод бэлтгэж байна.

2.1.10 Улсын хилийн зурваст Дадал сумын “Баянцагаан”, “Галттайн гол” Биндэр сумын “Сэрүүн баялаг”, “Хөмөл балж”, “Сэрүүн жаргалант Баянхаан” ойн нөхөрлөлүүд цэвэрлэгээний огтлолт хийж хилийн застав болон нутгийн иргэдийг түлээний модоор хангаж байна.


ОББЦГ-ын зөвшөөрөгдсөн бүсэд БОНХ-ийн сайдын тушаалаар батлагдсан ойн цэвэрлэгээг мэргэжлийн байгууллага болох “Балжхаан” ХХК, Хилийн 0287 дугаар ангийн 4, 5-р заставын ахуйн хэрэглээний болон түлээний модыг бэлтгэжээ.

Хилийн дагуух сумдад 2012 онд 223 га, 2013 онд 130 га, 2014 онд 173 га, 2015 онд 227 га талбайг орон нутаг, ААН өөрийн хөрөнгөөр ойжуулалт хийсэн боловч хилийн зурвас газарт ойжуулалт хийгдээгүй байна.

Ойн түймрээс урьдчилан сэргийлэх арга хэмжээ

2.1.11 Аймгийн ОБГ 2012 оны 11 дүгээр сарын 10-ны хооронд 25-30 албан хаагч, 3-4 автомашин, түймэр унтраах бусад багаж хэрэгсэлтэйгээр 186 км газарт 100-150 м өргөн хил дамнасан түймрээс хамгаалах зурвас, Хилийн 0287 дугаар анги 2013-2015 онд нийт 130 км 10-15 м өргөн ой хээрийн түмрээс хамгаалах зурвас

байгуулжээ. Шороон болон зориудаар шатаах аргаар зурвас байгуулсны үр дүнд 2012-2014 онд хил орчмын бүс нутагт ой хээрийн түймэр гараагүй байна.



Зураг: 2013-2015 онд байгуулсан ой хээрийн түймрээс хамгаалах шороон зурвас

ОХУ-аас 2015 оны 4 дүгээр сарын 15-нд орж ирсэн 2 дахь удаагийн түймэр салхины хурдаас шалтгаалан хамгаалалтын шороон зурвасыг давж ихээхэн хэмжээний хохирол учруулсан байна. Иймээс шороон зурвасны өргөнийг нэмэгдүүлэн, жил бүр дахин сэргээж байх нь түймрээс хамгаалахад чухал үр дүнтэй юм.



Зураг: Ой хээрийн түймрээс хамгаалах харлуулсан шатаах аргаар байгуулсан зурвас

Мөн аймгийн ОБГ нь 2014 онд Гамшгийн эрсдлийг бууруулах менежментийн зохицуулалтын чадавхийг сайжруулах МОН-13-301 төслийн 3,0 сая төгрөгийн санхүүжилтээр Биндэр сумын 80 малчин өрхийн өвөлжөө, хаваржаанд түймрээс хамгаалах хамгаалалтын зурвас байгуулан түймэр тархахаас урьдчилан сэргийлэх арга хэмжээ авч хэрэгжүүлжээ.

2.1.12 Хуурайшилтын улиралд автомашин, түймэр унтраах багаж хэрэгслээр хангагдсан шуурхай бүлгийг 2012 оноос эхлэн жил бүр хил орчмын сумдад ажиллуулснаар түймрээс урьдчилан сэргийлэх сургалт сурталчилгаа, мэдээллийг иргэдэд хүргэх, түймрийн эрсдэлтэй бүс нутагт тодорхой хугацаанд байрлан, түймрийн үеийн шуурхай байдлыг зохион байгуулж, ой хээрийн түймрээс урьдчилан сэргийлэх, шууд гарах зардал, цаг хугацааг хэмнэсэн үр дүнтэй ажил болжээ.



Ой хээрийн түймрээс урьдчилан сэргийлэх, тэмцэх чадавхийг дээшлүүлсэн нь

2.1.13 Хоёр улсын хооронд байгуулсан гэрээний дагуу жил бүр ОБГ-ын албан хаагчдыг ОХУ-ын Чита мужид зохион байгуулагдсан сургалтад хамруулдаг бөгөөд 2012-2014 онд түймэр унтраах болон аврах ажиллагааны чиглэлээрх сургалтад 13 албан хаагчийг хамруулжээ.

2.1.14 Монгол Улсын Засгийн газрын 2013 оны 106 дугаар тогтоолоор батлагдсан түймэр унтраах шаардлагатай багаж хэрэгслийн нөхөн хангалт, бэлэн байдлыг дээшлүүлэх зорилгоор Орон нутгийн төсвийн санхүүжилтээр 2 ш УАЗ-2206 маркын автомашин, 50 ш үлээгч, “FAW” маркын ус тээвэрлэгч автомашин 1 ш, ОБЕГ-аас 1 ш “Газель” маркын шуурхай албаны автомашин, 20 ш РЛО, галын нөмрөг 30ш, 40 ш үлээгч аппаратаар хангасан байна.

2.1.15 Байгаль орчин ногоон хөгжлийн сайдын 2012 оны 01 тоот албан даалгаврын хүрээнд аймгийн БОАЖГ-ын 2 мэргэжилтнийг томилж 18-22 цагийн хооронд тогтмол жижүүр ажиллуулж, орон нутгийн захиргааны байгууллага, байгаль хамгаалагч, ойн нөхөрлөлүүдтэй хамтран түймрийн эргүүл хяналтыг хэрэгжүүлж, иргэд аж ахуй нэгж, байгууллагуудад санамж анхааруулга тарааж, түймрийн эрсдэл өндөртэй сумдын ойд аялал зугаалга, мод бэлтгэл, ойн дагалт нөөц ашиглах үйл ажиллагааг хориглон зогсоосон байна.

Ойн түймрийн гаралт, унтраах ажил

2.1.16 Аймгийн ОБГ-аас томилсон шуурхай бүлгүүд нь 2015 онд Дадал сумын Хэрийн голын чиглэлд ОХУ-аас хил дамнан орж ирсэн эхний түймрийг нутгийн гүнд оруулалгүй хамгаалалтын зурваст тулган хохирол багатай унтраасан нь хилийн дагуу хамгаалалтын зурвас байгуулсан болон шуурхай бүлэг ажиллуулсны үр дүн юм.





“Хил дамнасан ой хээрийн түймрээс урьдчилан сэргийлэх, үр дагаврыг арилгах асуудлаарх” Монгол Улсын Дорнод аймаг, Хэнтий аймгуудын Онцгой байдлын хэлтэс, ОХУ-ын Иргэний хамгаалалт, Онцгой байдал байгалийн гамшгийн үр дагаврыг арилгах хэрэг эрхлэх яамны байгалийн хязгаар дахь Ерөнхий газар хоорондын байгуулсан 2010 оны 04-р сарын 13-ны хэлэлцээрийн 3 дахь хэсгийн 3.4 “Хил залгаа талын хүсэлтийн дагуу, хилийн болон гаалийн албаны

оролцоотойгоор хил залгаа улсын нутаг дэвсгэр дэх түймрийг унтраахад шаардлагатай хүч хэрэгслийг илгээнэ” гэсэн заалтын дагуу 2015 онд ОХУ-аас хил даван орж ирсэн эхний удаагийн түймрийг унтраах ажиллагаанд ОХУ-аас 10 хүн, 2 нэгж техник хэрэгсэл оролцсоныг дээрх зургаас харж болно.

Хэрийн голын чиглэлд ОХУ-аас орж ирсэн 2 дах удаагийн түймэр нь салхины хурдаас хамаарч хамгаалах шороон зурвасыг даван ихээхэн хэмжээний хохирол учруулсан байна. Энэ удаагийн түймэр өмнө хил дамнасан орж ирсэн тэмдэгтээр ОХУ-аас дахин орж ирсэн байна.

2.1.17 “Монгол улсын ОБЕГ, Оросын холбооны улсын ОБЯ-ны Өвөрбайгалийн хязгаар дахь Ерөнхий газрын онцгой байдлаас урьдчилан сэргийлэх, тэмцэх талаар 2015 онд хамтран ажиллах төлөвлөгөө”-нд:

- Хил залгаа нутаг дэвсгэрт гарсан улсын хил дамнасан түймрийн талаар шуурхай мэдээлэл солилцох, түймрийг унтраах дадлага сургууль зохион байгуулах
- Хил орчмын бүсэд ойн түймрээс урьдчилан сэргийлэх арга хэмжээг хэрэгжүүлэхэд хяналт тавих /түймрээс хамгаалах галын зон, зурвас татах болон бусад/
- Талуудын ойн түймэртэй тэмцэх нэгжүүдийг улсын хилээр хялбаршуулсан нөхцлөөр нэвтрэх дадлага сургуулийг талуудын тохирсны дагуу хилийн заставын орчмоор зохион байгуулах
- Монгол Улсын ОБА-ны аврагч гал сөнөөгчдийг ОХУ-ын Өвөрбайгалийн хязгаар дахь Ерөнхий газарт мэргэжил дээшлүүлэх сургалтад хамруулах талаар тусгажээ.

Хил дамнасан тархсан түймрийн талаарх мэдээллийг тухай бүр ОХУ-ын Мангут, Акшагийн хэсгийн Хилийн бүрэн эрхэт төлөөлөгч, аймгийн ОБГ-т-д мэдэгдэж харилцан мэдээлэл солилцож, 2015 оны 06 дугаар сард хил дамнасан болон хил орчмын түймрийн үед хил нэвтрэн түймэр унтраах дадлага сургууль, уулзалт зохион байгуулжээ.



2015 онд Хэнтий, Дорнод аймгийн БОАЖГ, улсын болон орон нутгийн төсвийн нийт 155,3 сая төгрөгийн хөрөнгө оруулалтаар, хилийн 795 тэмдэгтээс 3 улсын хил 0 дугаар тэмдгийн хооронд 280.1 км хэсэгт мөр хянах болон түймрээс урьдчилан сэргийлэх зурвасыг татаж хил хамгаалалт болон хил дамнан орж ирэх түймрээс хамгаалахад ашиглаж байна.

2.2 Хил орчмын усны чанар байдлын талаарх мэдээллийг иргэд байгууллагаас өгч байсан боловч усны мэргэжлийн байгууллага болох Онон голын сав газрын захиргаа тодорхой арга хэмжээ аваагүй байна

2.2.1 ОХУ-аас Батширээт, Биндэр, Дадал сумдын нутгаар нийт 26 гол, горхи орж ирдэг байна. Эдгээрээс Хэрийн, Гозуултай, Агац, Бөхөн, Хярхан, Чулуут, Галттай, Хөмөл, Балж, Ашинга зэрэг нийт 11 голоос усны дээж авч, газар дээр нь Бөхөн, Балж, Ашинга гол дээр биохимийн хэрэгцээт хүчилтөрөгч /БХХ-5/, ууссан хүчилтөрөгч O_2 , усны орчинг тодорхойлох /хүчиллэг, шүлтлэг, саармаг/ PH-ийг тодорхойлох, усны цахилгаан дамжуулах чадвар гэсэн 3 гол үзүүлэлтээр шинжилгээг хийж үзлээ.



Голын уснаас авсан дээж химийн урвалын үр дүнд усны чанар байдал хэрхэн өөрчлөгдөж, тунгалагшиж байгааг доорх зургаас харж болно.



ОХУ-аас Монгол Улсын хилээр дамжин орж байгаа голуудад аудитын явцад хийсэн урьдчилсан шинжилгээний дүн

Үзүүлэлт	Огноо	Сум	РН	ЕС	Ууссан хүчилтөрөгч	Координат	Усны температур	өнгө	тунгалагшил
Стандарт MNS 4586-98			6-9		6 мг/л				
1.Хэрийн гол	2015.10.26	Дадал	7.04	72.5 μ s		h-857 N49°25'23.1 E112°11'22.8	1.9°	үгүй	тунгалаг
2.Гозуултай гол	2015.10.26	Дадал	8.09	367 μ s		h-888 N49°20'14.9 E112°02'58.9	2.0°	үгүй	тунгалаг
3.Агц гол	2015.10.26	Дадал	7.80	83.7 μ s		h-930 N49°18'14.5 E111°42'27.8	1.1°	үгүй	тунгалаг
4.Бөхөн гол	2015.10.27	Дадал	8.45	75.3 μ s	6 мг/л	h-993 N49°15'25.4 E111°17'46.0	1.9°	үгүй	тунгалаг
5. Хярхан гол	2015.10.27	Дадал	8.16	81.3 μ s		h-1005 N49°14'01.9 E111°11'13.6	2.1°	үгүй	тунгалаг
6. Чулуут гол	2015.10.27	Дадал	9.03	217.0 μ s		h-1032 N49°11'10.5 E111°06'20.4	0.4°	үгүй	тунгалаг
7. Галтайн гол	2015.10.27	Биндэр	8.81	197.6 μ s		h-1033 N49°04'31.1 E110°47'15.8	1.3°	үгүй	тунгалаг
8. Хөмөл гол	2015.10.27	Биндэр	8.77	183.7 μ s		h-1128 N48°59'09.7 E110°36'07.7	1.7°	үгүй	Тунгалаг
9. Балж гол	2015.10.27	Биндэр	7.63	129.0 μ s	7.4м г/л	h-1131 N48°58'43.3 E110°36'20.2	2.4°	үгүй	тунгалаг
10.Амгалант гол	2015.10.27	Биндэр	7.83	179.2 μ s		h-1125 N48°57'59.9 E110°36'15.5	1.0°	Үгүй	Тунгалаг
11. Ашинга гол	2015.10.28	Батширээт	7.15	75.6 μ s	6.4м г/л	h-1246 N49°12'36.3 E109°47'43.4	0.4°	үгүй	тунгалаг

Тайлбар: Урьдчилсан шинжилгээгээр усан дах цахилгаан дамжуулах чанар, усан орчин, ууссан хүчилтөрөгчийн шинжилгээг хийсэн болно.

Тухайн гол дээр хийсэн анхан шатны урьдчилсан шинжилгээний дүнгээс үзэхэд Балж, Ашинга голууд нь MNS4586-98 стандартаар ууссан хүчилтөрөгчийн хэмжээ 0,4-1,4 мг/л-ээр илүү хэмжээтэй, өөрчлөлттэй байж болзошгүй байна. Иймд лабораторийн шинжилгээний дүнг нягтлан авч үзэх нь зүйтэй юм.

2.2.2 Аймгийн хэмжээнд Батширээт сумын Барх, Эгийн голд, Өмнөдэлгэр сумын Хурх голд, Дадал сумын Балж, Онон голд, Биндэр сумын Онон голд ус судлалын харуул ажиллаж байна. Ус судлалын харуул нь уснаас дээж авч, усны түвшин үзэх, өнгөрөлт хурдыг хэмжих, үерийн түвшин хэмжих, усны температур үзэх зэрэг үйл ажиллагааг явуулдаг байна.

2.2.3 УЦУОША-ны БОШ-ний лаборатори Онон-Дадал, Балж-Биндэр ус судлалын харуулаас ирүүлсэн хил орчмын Онон, Балж голын усны дээжид 2013, 2014 оны 6-10 дугаар сар, 2015 оны 4-6 дугаар сард шинжилгээ хийсэн гэх боловч энэ талаарх мэдээлэл УЦУОША-нд алга байна.

2.2.4 Хэлэлцээрийн дагуу орон нутаг дахь УЦУОША, ОХУ-ын адил төстэй байгууллагатай лабораторийн шинжилгээний дүнг солилцсон талаарх мэдээлэл баримт байхгүй байна.

2.2.5 “Онон голын сав газрын захиргаа” Хэнтий аймгийн Засаг даргын 2015.08.07-ны өдрийн А/399 тоот Уст цэгийн тооллого зохион байгуулах тухай захирамжийн дагуу 16,6 сая төгрөгийг орон нутгийн төсвөөс санхүүжүүлсэн гэх боловч хилийн ус болон бүсийн гол, нуур, булаг, худаг, рашааны тооллогыг зохион байгуулж байгаа гэсэн шалтгаанаар эзгүй байсан тул тодорхойлж чадсангүй. /Дарга Г.Мөнхбаттай 3 удаа утсаар ярьсан боловч нягтлан бодогч байхгүй, гэрээгээр хүн ажиллуулдаг, тайлан байхгүй байсан, өгсөн материал нь албан ёсны бус, гарын үсэг, тамга тэмдэггүй байлаа/

2.2.6 Онон голд цутгах Балж голын ус үе, үе бохирдож ногоон саарал өнгөтэй болж урсдаг тухай Хилийн 0287 дугаар ангийн удирдлага болон нутгийн иргэд / Ойн мэргэжлийн байгууллага ”ДОСНАР” ХХК-ийн захирал С.Батсайхан/ хэлж байлаа. Усны талаарх мэдээллийг Онон голын сав газрын захиргаанд тухай бүр хүргэсэн боловч тодорхой арга хэмжээ аваагүй байна.

2.3 Хан Хэнтийн тусгай хамгаалалттай газрын хамгаалалтын захиргаа, ОББЦГ-ын хамгаалалтын захиргаа нь хил хамгаалах байгууллага, орон нутгийн засаг захиргааны байгууллагатай хамтарч ажиллаж байгаа гэх боловч аймгийн БОАЖГ-т хамтран ажиллаж байгаа талаарх мэдээлэл байхгүй байна.

Хан Хэнтий ТХГ ба Батширээт сумын хамтын ажиллагааны талаар

2.3.1 Хан Хэнтий ТХГ-ын захиргаа Батширээт суманд биологийн төрөл зүйлийг хамгаалах, байгалийн нөөцийг зүй зохистой ашиглахад тулгарч буй асуудлуудыг шийдвэрлэхэд хамгаалалтын хэсэг, сум, баг, нутгийн иргэдийн хамтын ажиллагааг сайжруулах, байгаль орчны мэдээлэл түгээх, сурталчилгааны ажлыг сайжруулах чиглэлээр үйл ажиллагаа явуулдаг байна.

Хан Хэнтийн ТХГН-ын захиргаа 2013 оноос эхлэн Хилийн 0151 дүгээр ангийн Минжийн застав, Сэлэнгэ аймгийн Хүдэр сум дахь хилийн 0236 дугаар салбар,

Батширээт сумын нутаг дахь хилийн 0279 дүгээр ангийн Ононгийн заставын удирдлагуудтай, Хил орчмын байгаль орчныг хамгаалах, ногоон хөгжлийг дэмжих чиглэлээр БОНХ-ийн яам ХХЕГ 2013-2015 оны хугацаанд хамтран ажиллах санамж бичгийн хүрээнд Ононгийн заставын удирдлагуудтай жил бүр хамтран ажиллах гэрээ байгуулан ажиллажээ.

Мөн Дадал сум дахь Хилийн 0287 дугаар ангитай сансрын ИРИДИУМ утас ашиглуулах талаар гэрээ байгуулан ажиллажээ. Идэвхтэн байгаль хамгаалагч ажиллуулах журмын дагуу 25 иргэнд үнэмлэх олгон хамтран ажиллаж, тэдний нэр бүхий 14 идэвхтэн байгаль хамгаалагчдад нийт 1950,0 мянган төгрөгийн урамшуулал олгосон байна.

2.3.2 Гэрээний дагуу 2011 оноос эхлэн Монгол Улс ОХУ-ын хилийн дагуух амьтны нүүдлийг татах зорилгоор биотехникийн хэрэгжүүлсэн МАРАА-1 төслийн үр дүнд үндэслэн 2013 онд МАРАА-2 төслийг боловсруулан Онон, Минжийн застав, зарим сумдын орчны бүсийн зөвлөл, ИТХ-ын төлөөлөгчид, идэвхтэн байгаль хамгаалагчидтай хамтран Батширээт сумын нутагт хужир мараа тарих ажлыг гүйцэтгэж төслийг хэрэгжүүлжээ.



Онон Балжийн байгалийн цогцолборт газрын хамгаалалтын захиргаа орон нутгийн байгууллагуудын хамтын үйл ажиллагааны талаар

2.3.3 Онон Балжийн БЦГ-ын хамгаалалтын захиргаа, Сохондын ШМДГ-ын захиргаатай 2009 оноос жил бүр хамтран ажиллах төлөвлөгөөтэй ажиллаж ирсэн бөгөөд Монгол Улсын ОББЦГ-ын хамгаалалтын захиргаа, ОХУ-ын Сохондын ШМДГ-ын захиргаатай 2013 онд хамтран ажиллах төлөвлөгөөнд

- Ой хээрийн түймрээс урьдчилан сэргийлэх хамтын ажиллагаа
- Хамтарсан судалгаа явуулж хамтын ажиллагааны ажлын уулзалт зохион байгуулах
- Цагаан зээр, тоодог, тарвага, тогорууны хамгаалалт ажиглалтын арга хэмжээг хэрэгжүүлэх ажлыг зохион байгуулах зэрэг талаар тусгасан

Сохондын ШМДГ-тай гэрээ байгуулж байгаа нь

Хамтарсан судалгаа



2.3.4 Сохондын ШМДГ болон Хан Хэнтийн тусгай хамгаалалттай газар нутгуудад улсын хил дамнан нүүдэллэдэг зүйлүүд, ойн туруутны цөм байршил, зүйлүүдийн хөдөлгөөн, тоо толгойг тогтоох, нэн ховор, ховор шувуудын мониторинг судалгааг ОББЦГ-ын хязгаарлалтын бүсэд жилд 2-3 удаа хамтарсан судалгаа хийж, хамтын ажиллагааг зохион байгуулсан байна.

Цэн тогорууны нүүдэл

Цэн тогорууны цугларалт



2.3.5 Онон Балжийн БЦГ-ын хамгаалалтын захиргаа Дадал, Биндэр, Батширээт, Баян-Адрага, Норовлин сумын ЗДТГ, Дорнод аймгийн Баян-Уул сумын Засаг дарга, хилийн 0287 дугаар ангитай хамтран ажиллах гэрээ байгуулан хилийн бүс нутагт

байгаль орчны хууль тогтоомжийн хэрэгжилтэд хяналт тавих, байгаль, цаг уурын гамшгийн үед харилцан мэдээлэл солилцох, иргэдийн байгаль орчны боловсролыг дээшлүүлэх чиглэлээр хамтран ажиллаж байна.



2.3.6 ОХУ-ын Сохондын ШМДГ-ын захиргаа, Хилийн 0287 дугаар анги, Дадал, Биндэр, Норовлин сум, Дорнод аймгийн Баян-Уул сумын Засаг даргатай жил бүр хамтран ажиллах гэрээ байгуулан, батлагдсан төлөвлөгөөний дагуу биелэлтийг тооцон ажиллажээ. Хилийн 0287 дугаар ангитай хамтран 2012-2014 оны 10-11 дүгээр саруудад хууль бус ан агнууртай тэмцэх "Онгон байгаль" хяналт шалгалтын арга хэмжээг ОББЦГ-ын "А", "Б" хэсгүүдэд 3 удаа зохион байгуулжээ.

Онон голын сав газрын захиргааны үйл ажиллагааны талаар

2.3.7 Онон голын сав газар нь 2013 оны 8 дугаар сард байгуулагдсан бөгөөд аймгийн Засаг даргын захирамжаар 2015 оны 5, 6 дугаар сард хилийн 0287, 0275 дугаар ангиудтай хамтран орон нутгийн төсвийн хөрөнгөөр хилийн ус болон нуур, булаг, худаг, рашааны тооллогыг зохион байгуулж, Онон голын ай савд багтах томоохон голын судалгаа хийж байна.

**ГУРАВДУГААР
БҮЛЭГ**


**• ХИЛ ОРЧМЫН БАЙГАЛЬ ОРЧНЫГ ХАМГААЛАХАД
ЗОРИУЛСАН УЛС, ОРОН НУТГИЙН ТӨСВИЙН
ХӨРӨНГИЙН ЗАРЦУУЛАЛТ**

3.1. Улс орон нутгийн төсвөөс хил орчмын байгаль хамгаалахад тусгайлан хөрөнгө төлөвлөөгүй, шороон зурвас байгуулах хөрөнгө хангалттай хүрэлцэхгүй байна.

Аймгийн байгаль орчныг нөхөн сэргээх зардалд 2013 онд 516,7 сая төгрөг, 2014 онд 346,6 сая төгрөг, 2015 онд 329,5 сая төгрөг буюу нийт 1192,8 сая төгрөгийн төсөв батлагдсанаас хил орчмын байгаль орчныг хамгаалах зардалд нийт 67,5 сая төгрөгийг зарцуулахаар төлөвлөсөн байна. Тухайлбал,

- 2014 онд Биндэр сумын Гутайн даваанд ойн түймрээс хамгаалах ойн халз зурвас байгуулахад 15,0 сая төгрөг, Түймрийн тархалтаас урьдчилан сэргийлэх Биндэр сумаас Дадал сум хүртэл хил дагуулан зориудаар шатаах аргаар 170 км зурвас гаргахад 20,0 сая төгрөг,
- 2015 онд Улсын хилийн дагуу ойн түймрээс хамгаалах 77 км харлуулсан шороон зурвасыг Дадал, Биндэр сумын нутагт өмнөх жилийн зурвасаас үргэлжүүлэн хийхэд 18,5 сая төгрөг,
- Түймэр унтраах шуурхай 5 бүлгийн бэлэн байдлыг хангахад 14,0 сая төгрөгийг тус тус тусгасан байна.

2012-2015 онд ой хээрийн түймрээс хамгаалахаар байгуулсан зурвасын уртыг графикаар үзүүлбэл:



Шороон зурвас байгуулах ажилд хөрөнгө төлөвлөж зарцуулсан боловч байгуулсан шороон зурвасын өргөн түймрээс бүрэн хамгаалах хэмжээнд хүрэхгүй, мөн өмнөх онд байгуулсан зурвасыг дахин сэргээх зардал төлөвлөгдөөгүй байна.

3.1.1 Хил орчмын байгаль орчныг хамгаалахад тусгайлан хөрөнгө төлөвлөгдөөгүй боловч аймгийн хэмжээнд 2012-2015 онд хил орчмын байгаль орчныг хамгаалахтай холбоотой хийгдсэн дараах ажлуудад аймгийн БОАЖГазар, Онцгой байдлын газар, Хилийн 0287 дугаар анги, Онон-Балжийн БЦГ-ын Хамгаалалтын захиргаа, Онон голын сав газрын захиргаа, Хан Хэнтийн ТХГН-ийн Хамгаалалтын захиргааны газар зэрэг байгууллагууд нь 342,6 сая төгрөгийн хөрөнгийг зарцуулжээ. Үүнд:

- Орон нутгийн төсвөөс 169,3 сая төгрөг,
- Аймгийн Засаг даргын нөөц сангаас 11,7 сая төгрөг,
- БОНХЯамнаас 120,0 сая төгрөг,

- Дэлхийн байгаль хамгаалах сангаас 11,7 сая төгрөг,
- Онон-Балжийн БЦГ-ын ХЗ 15,0 сая төгрөг,
- Хан Хэнтий ТХГН-ын ХЗ 1,9 сая төгрөг,
- НҮБ-ийн Гамшгийн эрсдлийг бууруулах МЗЧС-х МОН-13 төсөл 12,0 сая төгрөг,
- ОБГазар 0,3 сая төгрөг,
- Дэлхийн зөн ОУБ 0,6 сая төгрөгийн хөрөнгө зарцуулжээ. /хавсралтаар үзүүлэв/

Хил орчмын байгаль орчныг хамгаалахад зарцуулсан төсвийн хөрөнгө бүрэн зарцуулагдсан байна.

3.1.2 Хэнтий аймагт хил орчмын байгаль хамгааллын чиглэлээр ой хээрийн түймрээс хамгаалах, шороон зурвас байгуулах, сэргээх, дахин боловсруулах ажлын хүрээнд 2013-2015 онд нийт 86,4 сая төгрөг зарцуулсан байна /2013 онд 41,9 сая төгрөгийн, 2014 онд 26,2 сая төгрөгийн санхүүжилтийг БОНХЯ-наас, 2015 онд 18,5 сая төгрөгийн санхүүжилтийг Орон нутгийн төсвийн байгаль орчныг нөхөн сэргээх зардлаас/

Мөн 2012 онд БОНХЯ-ны 8,0 сая төгрөгийн санхүүжилтээр хил орчмын ховор ургамлын тандалт, судалгааг хийсэн байна.

3.2.2 Хил орчмын сумдад хил дамнасан ой, хээрийн түймрээс сэргийлэх, тэмцэхэд зориулж Хэнтий аймгийн Онцгой байдлын газрыг түймэр унтраах зориулалтын техник, багаж хэрэгслээр хангах, Хил хамгаалах анги болон заставуудыг түймэртэй тэмцэх техник, багаж хэрэгслээр хангах ажлын хүрээнд нийт 126,2 сая төгрөгийг, гамшгаас урьдчилан сэргийлэх сургалт сурталчилгаанд 42,0 сая төгрөгийг тус тус зарцуулсан байна.

Хэнтий аймагт агнуурын бүс тогтоох, нарийвчилсан агнуур зохион байгуулалт хийх, менежментийн төлөвлөгөөг боловсруулах ажлыг 2013 онд 26,0 сая төгрөгөөр гүйцэтгэж, хил орчмын сумдад /Дадал, Батширээт, Биндэр, Өмнөдэлгэр/ агнуурын бүсүүдийг тогтоон, нарийвчилсан агнуур зохион байгуулалт хийж, БОНХЯ-аар батлуулсан байна.

3.2.3 Хил орчмын байгаль орчныг хамгаалахтай холбоотой агнуурын бүсэд биотехникийн арга хэмжээ хэрэгжүүлэх, ховор амьтад, шувууд, ургамлын судалгаа хийх болон түймрээс урьдчилан сэргийлэхтэй холбоотой шороон зурвас байгуулах, сэргээх ажил, түймрээс урьдчилан сэргийлэх багаж хэрэгсэл авах, шуурхай бүлэг ажиллуулах, айл өрх, малчдад сургалт сурталчилгаа хийх зэрэг ажлуудад төлөвлөсөн 342,6 сая төгрөгийг бүрэн зарцуулсан байна.

3.3. Түймрээс учирсан хохирлын экологи, эдийн засгийн үнэлгээг сумын Засаг даргын захирамжаар томилогдсон комисс тогтоожээ.

3.3.1 Хэнтий аймгийн нутагт 2012-2014 онд хил дамнасан түймэр гараагүй бөгөөд 2015 онд ОХУ-аас хил дамнан орж ирсэн 2 удаагийн түймэрт 33,6 мянга га ой, 40,8 мянган га хээр шатаж, 15837,0 сая төгрөгийн экологийн хохирол, 43,0 сая төгрөгийн эд материалын хохирол учирч, түймэр унтраахад 10,4 сая төгрөгийн зардал нийт 15890,4 сая төгрөгийн хохирол учирсан байна.

Түймэрт өртсөн сумдын Засаг дарга нар хохирол тогтоох ажлын хэсгийг томилж түймрийн хохирлын хэмжээг 15 847,4 сая төгрөгөөр тогтоосон байна.

№	Хил дамнан орсон тэмдэгт	Түймэрт хамрагдсан сум, газар	Огноо		Шатсан талбай /мян.га/		Экологийн хохирол /сая.төг/	Унтраахад гарсан зардал /сая.төг/	Эд /мат хохирол /сая.төг/
			Орж ирсэн	Унтраасан	ой	хээр			
1	827-828	Дадал. Хэрийн гол	2015.04.10	2015.04.11	3,919	22,588	2 422 ,7	2,7	43,0
2	828	Дадал. Хэрийн гол	2015.04.15	2015.04.30	29,698	18,200	13 414,3	7,7	-
	Дүн				33,617	40,788	15 836,9	10,4	43,0
	Нийт дүн				74,405		15890,4		

ДҮГНЭЛТ

- 2010 оны “Хил дамнасан ой хээрийн түймрээс урьдчилан сэргийлэх, үр дагаварыг арилгах асуудлаарх” Дорнод, Хэнтий аймгуудын Онцгой байдлын хэлтэс, ОХУ-ын Иргэний хамгаалалт, Онцгой байдал байгалийн гамшгийн үр дагаврыг арилгах хэрэг эрхлэх яамны Байгалийн хязгаар дахь ерөнхий газар хоорондын байгуулсан хэлэлцээр, харилцан туслалцах заалтын дагуу ОХУ-аас 10 хүний бүрэлдэхүүн, 2 тээврийн хэрэгсэлтэй улсын хилээр нэвтрэн, хээрийн түймэр унтраах ажилд тусласан байна.
- Монгол Улс, ОХУ-ын Засгийн газрын хооронд “Хилийн усыг хамгаалах, ашиглах тухай” хэлэлцээрийн заалтууд 2012-2015 онд орон нутагт хэрэгжээгүй байна.
- Хил орчмын ховор ургамал, амьтныг хамгаалах, хамтран судлах гэрээ хэлэлцээрийн дагуу ОХУ-ын Сохондын ШМДГ, ОББЦГ-ын хамгаалалтын захиргаатай хамтран нэн ховор, ховор шувуудын судалгаа хийжээ.
- Хэнтий, Дорнод аймгийн нутгаар хил дамнасан гарч байгаа ой хээрийн түймрээс сэргийлэх, хамгаалах зорилгоор шороон зурвас байгуулсан боловч, шороон зурвасыг дахин нөхөн сэргээлт хийгдэхгүй байгаагаас уг төсвийн хөрөнгө үр ашиггүй, үр нөлөөгүй зарцуулсан байдалд хүрч болзошгүй байна
- Ой хээрийн түймрээс урьдчилан сэргийлэх, хамгаалах аймгийн зөвлөл байгуулагдсан боловч зөвхөн ажиллах дүрэм, журам батлахаас өөр ажил хийгдээгүй байна.
- ОХУ-аас Биндэр сумын нутаг “Балж гол”-ын ус ногооноор урсаж байсан тухай мэдээллийг иргэд, хил хамгаалах анги, салбараас усны мэргэжлийн байгууллага болох Онон голын сав газрын захиргаанд өгч байсан боловч тодорхой арга хэмжээ аваагүй байна.
- Хан Хэнтийн тусгай хамгаалалттай газрын хамгаалалтын захиргаа, ОББЦГ-ын хамгаалалтын захиргаа нь хил хамгаалах байгууллага, орон нутгийн засаг захиргааны байгууллагатай хамтарч ажиллаж байгаа гэх боловч аймгийн БОАЖГ-т хамтран ажиллаж байгаа талаарх мэдээлэл байхгүй байна.
- Хэнтий аймгийн Дадал, Биндэр, Батширээт сумын захиргаа улс, орон нутгийн төсвөөс хил орчмын байгаль орчныг хамгаалахад тусгайлан хөрөнгө төлөвлөөгүй, шороон зурвас байгуулахад дэмжлэг туслалцаа үзүүлээгүй байна.
- Ой хээрийн түймрээс учирсан хохирлын экологи, эдийн засгийн хохирлын хэмжээг сумын Засаг даргын захирамжаар томилогдсон комисс тогтоож байгаа боловч энэ хохирлыг барагдуулах ажил үр дүнгүй болж байна.

ЗӨВЛӨМЖ

Аймгийн Засаг дарга Ж.Оюунбаатарт

- Ой хээрийн түймрээс урьдчилан сэргийлэх, хамгаалах, зохицуулах зөвлөлийн үйл ажиллагааг батлагдсан дүрэмд заагдсаны дагуу удирдан чиглүүлэн ажиллуулж, тайлагнаж байх
- Хил орчмын байгаль хамгаалахад зориулан жил бүр орон нутгийн төсөвт тусгайлан хөрөнгө тусгуулах саналыг оруулж, аймгийн ИТХ-аар батлуулах
- Хил дамнан гарч байгаа ой хээрийн түймрээс урьдчилан сэргийлэх, хамгаалах зорилгоор байгуулсан шороон зурвасыг дахин сэргээх, зурвасын өргөнийг нэмэгдүүлэх асуудлыг холбогдох байгууллагад уламжлан шийдвэрлүүлэх.

Хилийн 0287 дугаар ангийн захирагч, хурандаа Ж.Жамсрандоржид

- Хил дамнан гарч байгаа ой хээрийн түймрээс урьдчилан сэргийлэх, хамгаалах зорилгоор байгуулсан шороон зурвасыг дахин сэргээх, зурвасын өргөнийг нэмэгдүүлэх талаар ХХЕГ-т уламжлан хөрөнгийн эх үүсвэрийг шийдвэрлүүлэх, энэ талаар төсөл, хөтөлбөр болон орон нутгийн байгууллагуудтай хамтран ажиллах

Аймгийн ОБГ-ын дарга Д.Батжаргалд

- Хил дамнасан ой хээрийн түймрээс урьдчилан сэргийлэх талаар ОХУ-ын холбогдох байгууллагуудтай байгуулсан хэлэлцээрийн хэрэгжилтийг хангах ажлыг сайжруулах, үр дүнг дүгнэж байх

Аймгийн УЦУОША-ны дарга Л.Чулуунд

- Хил дамнан орж, гарч байгаа гол горхины усны чанар байдалд сар, улирал бүр лабораторийн шинжилгээ хийж, дүгнэлтийг орон нутагт мэдээлдэг байх

Аймгийн БОАЖГ-ын дарга Г.Энхбаярт

- Хил орчмын байгаль хамгаалахад зориулан жил бүр улсын болон орон нутгийн төсөвт тусгагдсан хөрөнгийг үр ашигтай зарцуулах төлөвлөгөө гаргаж, аймгийн ЗД-аар батлуулан, хэрэгжилтэд хяналт тавьж, үр дүнг улирал тутам АЗД-ын зөвлөлөөр хэлэлцүүлэн ажиллах

Сумдын Засаг дарга нарт

- Ой, хээрийн түймрээс хамгаалах, урьдчилан сэргийлэх бодлогыг хэрэгжүүлэх, хөрөнгийн эх үүсвэрийг орон нутгийн төсөвт тусгаж байх

Зөвлөмжийн хэрэгжилтийг 2016 оны 06 дугаар сарын 25-ны дотор аймгийн Аудитын газарт ирүүлнэ үү.

Тайлан бичсэн: Ахлах аудитор

Н.Туяа

Шинжээч

Б.Мөнгөнцэцэг

2015 оны 10 дугаар сарын 30

Холбогдох байгууллагаас ирүүлсэн санал:

1.Аймгийн БОАЖГазраас ирүүлсэн албан тоот:



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАРТ

Хилийн бүсэд ой, хээрийн түймрээс урьдчилан сэргийлэх үр дүнтэй ажил бол түймрээс хамгаалах хамгаалалтын зурвас татах юм. Харлуулсан шороон зурвас татах нь түймрээс хамгаалах, ан амьтны аюулгүй байдал болон хилийн аюулгүй байдлыг хамгаалах, хил зөрчигчийн мөр хянах өндөр ач холбогдолтой юм. Иймд:

1. Харлуулсан шороон зурвасны өргөн 10м байгааг нэмж 50 м хүртэл өргөн болгох
2. Жил бүр дахин хагалж арчилгаа хийх
3. Харлуулсан шороон зурвасны өргөнийг нэмэх болон арчилгаа хийх зардлыг Монгол улсын Шадар сайд, Байгаль орчин, ногоон хөгжил, аялал жуулчлалын сайд, Батлан хамгаалахын сайдын багцад тусгуулах саналтай байна.

ДАРГА



Г.ЭНХБАЯР

2. Аймгийн ОБГ-аас ирүүлсэн санал:



**ХЭНТИЙ АЙМАГ
ОНЦГОЙ БАНДЛЫН ГАЗАР**
23110 Чангис, Харлан сум,
Утас/Факс: (976)-7056-3024
Эмэйл: www.khenti.com.mongol
E-mail: emet.khenti@yahoo.com

2015.10.29 № 37/427

талай _____ -ны № _____ -т

**ҮНДЭСНИЙ АУДИТЫН
ГАЗАРТ**

Тус аймгийн 4 сум ОХУ-тай хил залгаа оршдог бөгөөд хавар, намрын улиралд хил орчмын болон хил дамнасан түймэр гарч ихээхэн хохирол учруулдаг юм. Үүнээс урьдчилан сэргийлэх зорилгоор хил дагуу 2005 оноос харлуулах зурвасыг 60-100 метрийн өргөнтэй байгуулж ирсэн ба 2013 оноос газрыг хагалан хамгаалалтын зурвас байгуулж байна.

Одоо хийгдэж буй хамгаалалтын зурвасын өргөн 10 метр, гүн 20 см байгаа нь хил дамнасан орж ирсэн түймрийг хязгаарлах боломж бага тул нэмж өргөсгөн 30-50 метр болгох эсвэл давхар харлуулах зурвас татах шаардлагатай байгаа юм.

Мөн хилийн заставуудыг ой, хээрийн түймэр унтраах багаж хэрэгсэлээр хангах талаар холбогдох газруудад асуудлыг тавьж шийдвэрлүүлж өгөхийг хүсье.

ДАРГА, ОНЦГОЙ БАЙДЛЫН
ХУРАНДАА _____ Д.БАТЖАРГАЛ



СНХА-02.02.01.01.0005

3. Дадал сумын Засаг даргаас ирүүлсэн санал:


**ХЭНТИЙ АЙМАГ
ДАДАЛ СУМЫН ЗАСАГ ДАРГА**

23000 Баян-Овоо, Дадал сум,
И-мэйл: dadal_khenti@yahoo.com


2015.10.26 № 1/59
Хүний _____-ийн _____-д

**ҮНДЭСНИЙ АУДИТЫН
ГАЗАРТ**

Тус суманд 2013-2015 онд Орон нутгийн төсвийн хөрөнгө, Байгаль хамгаалах, нөхөн сэргээх зардлаар хилийн бүсэд хил орчмын түймрээс хамгаалах, урьдчилан сэргийлэх зорилгоор хийгдсэн харлуулсан шороон зурвас нь ОХУ-аас орж ирдэг ой хээрийн түймрээс хамгаалах, байгаль орчин их хэмжээгээр сүйтгэхээс хамгаалагдах ач холбогдолтой юм.

Цаашид арчлах, хамгаалах төсөв хөрөнгийн асуудлыг дээд шатны байгууллагад уламжлан шийдвэрлүүлэх шаардлагатай байна.

**ЗАСАГ ДАРГЫН
ОРЛОГЧ**  **О.БАТСАЙХАН**





ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗРЫН ХАРЬАА
ХЭНТИЙ АЙМГИЙН АУДИТЫН ГАЗРЫН ДАРГЫН
ТУШААЛ

2015 оны 10 сарын 30 өдөр

Дугаар 39

Өндөрхаан хот

Гүйцэтгэлийн аудитын тайланг
батлах тухай

Монгол Улсын Ерөнхий аудиторов 2014 оны 121 дүгээр тушаалаар батлагдсан “Нийслэл болон аймгийн аудитын газрын дарга, тэргүүлэх аудиторуудад зөвшөөрөх бүрэн эрх”-ийн 5, аймгийн Аудитын газрын Удирдах зөвлөлийн 2015 оны 10 дүгээр сарын 30-ны өдрийн хурлын тэмдэглэлийг үндэслэн ТУШААХ НЬ:

1. “Хил орчмын байгаль орчныг хамгаалах талаарх төрийн зохицуулалтын үр нөлөөт байдал”-д хийсэн гүйцэтгэлийн аудитын тайланг баталсугай.
2. Гүйцэтгэлийн аудитын тайланг УАГ-т тайлагнаж, аймгийн ИТХ-д танилцуулж, Засаг даргад хүргүүлэхийг ахлах аудитор Н.Туяад даалгасугай.
3. Гүйцэтгэлийн аудитаар өгсөн зөвлөмжийн биелэлтэд хяналт тавьж ажиллахыг аудитын менежер Б.Наранцэцэгт үүрэг болгосугай.

ДАРГА,
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Ц.ЭНХТҮВШИН

0200072

Хавсралт № 01

Он	Хэрэгжүүлсэн үйл ажиллагаа	Зарцуул сан дүн /сая.төг/	санхүүжилтийн эх үүсвэр
2013	Агнуурын бүс тогтоох, нарийвчилсан агнуур зохион байгуулалт хийх, менежментийн төлөвлөгөө боловсруулах	26.0	орон нутгийн төсвийн хөрөнгө
	Ойн түймрээс у/с-х сургалт	4.0	орон нутгийн төсвийн хөрөнгө
	Түймрийн тархалтаас у/с-х	20.0	орон нутгийн төсвийн хөрөнгө
2014	Ойн түймрээс у/с-х сургалт	4.0	орон нутгийн төсвийн хөрөнгө
	Түймрийн тархалтаас у/с-х Биндэрээс Дадал сум хүртэл хил дагуу/зориудаар шатаах аргаар зурвас гаргах/	20.0	орон нутгийн төсвийн хөрөнгө
	Түймрийн тархалтаас у/с-х	15.0	орон нутгийн төсвийн хөрөнгө
	Биндэр сумын Гутайн даваанд түймрээс хамгаалах ойн халз зурвас	15.0	орон нутгийн төсвийн хөрөнгө
	Биотехникийн арга хэмжээний зардал	2.5	орон нутгийн төсвийн хөрөнгө
	Батширээт "Онон тарс" ТББ мод оржүүлэг	2.5	орон нутгийн төсвийн хөрөнгө
2015	Агнуурын бүс нутагт мониторинг судалгаа хийх	2.4	орон нутгийн төсвийн хөрөнгө
	Агнуурын бүсэд биотехникийн арга хэмжээ	3.0	орон нутгийн төсвийн хөрөнгө
2015	Ой, хээрийн түймрээс хамгаалах шороон зурвас байгуулах, сэргээх, дахин боловсруулах ажил	18.3	орон нутгийн төсвийн хөрөнгө
2015	Усны тооллого зохион байгуулах	16.6	Орон нутгийн төсвийн хөрөнгө
2015	Түймэр унтраах шуурхай бүлэг /2/	14.0	орон нутгийн төсвийн хөрөнгө
2015	Ой хээрийн түймрийн бэлэн байдлын үзлэг /2/	6.0	орон нутгийн төсвийн хөрөнгө
	Орон нутгийн төсвөөс зарцуулсан дүн	169.3	
2012	Өмнөдэлгэр, Батширээт, Биндэр, Дадал сумдад гамшгаас хамгаалах сургалт, сурталчилгаа, у/с-х арга хэмжээ	4.8	Аймгийн Засаг даргын Нөөц сан

2013	Өмнөдэлгэр, Батширээт, Биндэр, Дадал сумдад гамшгаас хамгаалах сургалт, сурталчилгаа, у/с-х арга хэмжээ	4.4	Аймгийн Засаг даргын Нөөц сан
2015	Ой хээрийн түймрээс урьдчилан сэргийлэх болзолт уралдаан	2.5	Аймгийн Засаг даргын Нөөц сан
Аймгийн Засаг даргын Нөөц сангаас зарцуулсан дүн		11.7	
2012	Ховор ургамлын тандалт судалгаа	8.0	БОНХЯ-ны санхүүжилт
2013	Улсын хил орчмын нэн ховор, ховор амьтдын судалгааны ажил	3.0	БОНХЯ-ны санхүүжилт
2013	Ой, хээрийн түймрээс хамгаалах шороон зурвас байгуулах, сэргээх, дахин боловсруулах ажил	41.9	БОНХЯ-ны санхүүжилт
2014	Ой, хээрийн түймрээс хамгаалах шороон зурвас байгуулах, сэргээх, дахин боловсруулах ажил	26.2	БОНХЯ-ны санхүүжилт
2014	шаардлагатай 54 цэгт тэмдэг, тэмдэглэгээ, хаалт хийх ажил	41.0	БОНХЯ-ны санхүүжилт
БОНХЯ-ны санхүүжилтийн дүн		120.0	
2013	Хамтарсан судалгааны зардал	2.0	Онон-Балж БЦГ-ын төсөв
	Улсын хилийн дотогш зэрлэг амьтдыг татах зорилготой хадлан бэлтгэх, өвс тэжээл, хужир, шүү тавих биотехникийн арга хэмжээг Онон-Балжийн БЦГ-т хэрэгжүүлэх.	4.6	Онон-Балж БЦГ-ын төсөв
2014	Онон-Балжийн БЦГ түүний охчны бүсэд цагаан зээр, цэн тогоруу, хонин тоодог болон ховор зүйлийн бусад шувууд, хөхтөн амьтад, ховор ургамлын хээрийн судалгааг хийж, зэрлэг амьтдын шилжилт хөдөлгөөнийг судлан, хяналт шалгалт хийх	0.4	Онон-Балж БЦГ-ын төсөв
	Биотехникийн арга хэмжээ хэрэгжүүлэх	6.0	Онон-Балж БЦГ-ын төсөв
	Дорнод аймгийн Баян-Уул сумын Хясуу хэмээх газар байгаль хамгаалагчийн жишиг байр барих ажил	2.0	Онон-Балж БЦГ-ын төсөв
Онон-Балжийн БЦГ-ын ХЗ-ний зарцуулсан дүн		15.0	

2014	Малчин өрхийн өвөлжөө хаваржаанд түймрээс хамгаалах зурвас байгуулах	3.0	Гамшгийн эрсдлийг бууруулах МЗЧС-х МОН-13-301 төсөл
2014	Гамшгаах хамгаалах бэлэн байдал, сургалт сурталчилгаа, түймэр унтраах багаж хэрэгсэл	9.0	Гамшгийн эрсдлийг бууруулах МЗЧС-х МОН-13-301 төсөл
	Гамшгийн эрсдлийг бууруулах МЗЧС-х МОН-13-301 төслөөс зарцуулсан дүн	12.0	
2012	Хамгаалалтын зурвас	11.3	Дэлхийн байгаль хамгаалах сан
2012	Онон-Балжийн БЦГ нутагт цагаан зээр, ховор зүйлийн шувууд, хөхтөн, ургамлын хамтарсан судалгаа хийх	0.4	Дэлхийн байгаль хамгаалах сан
	Дэлхийн байгаль хамгаалах сангийн зарцуулсан дүн	11.7	
2014	Идэвхтэн байгаль хамгаалагчийг урамшуулах зардал	2.0	Хан Хэнтий ТХГН-ын ХЗ
2012	Удирдах ажилтны сургалт	0.6	Дэлхийн зөн Монгол ОУБ-ын Бор-Өндөр-2 төсөл
2012	Мэргэжлийн ангийн сургалт	0.3	Аймгийн ОБГ
	Нийт дүн	342.6	